

**ТӨРИЙН БАНКНЫ ОРОН НУТГИЙН ТООЦООНЫ ТӨВИЙН
БАРИЛГЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

2020.02.10

1	Барилга байгууламжийн байршил	Хөвсгөл аймаг Улаан-Уул тооцооны төв	
2	Хүчин чадал: (бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний нэр төрлөөр)	Зориулалт	Банкны үйлчилгээний
		Хэмжээ	10,0м х 9,0м
		Давхрын тоо	1 давхар
3	Ажиллах горим	Ердийн	
4	Үйлдвэр, аж ахуйн газар, барилга байгууламжийн бүрэлдэхүүн	Банкны үйлчилгээний зориулалттай 1 давхар барилга	
5	Барилгын үндсэн бүтээц, материал	Суурь	Цутгамал төмөр бетон баганан суурь
		Хана	Блок, дулаалгатай металл хавтан
		Хучилт	Цутгамал төмөр бетон
		Гадна тохижилт	Өөрийн эзэмшлийн газрын хэмжээгээр 40см-ийн өндөртэй бетон суурьтай, 1,1м-ийн өндөртэй профиль төмөр хашаа, явган зам, талбай, хашааны гадна автомашины нягтруулсан шороон зогсоол, явган зам талбай, гадна гэрэлгүүлэг, түлээ нүүрсний байр, стандартын шаардлага хангасан модон жорлонтой байна.
6	Инженерийн шугам, сүлжээ түүнийг хангах эх үүсвэр	Дулаан	Нам даралтын болон цахилгааны хосолмол зуух /зурагт заасан үзүүлэлтийг хангасан байх/
		Цахилгаан	Техникийн нөхцлийн дагуу
7	Зураг төслийн баримт зохиох үе шат	Геологийн дүгнэлт, барилгын батлагдсан зургийг захиалагчаас авна.	
8	Захиалагч байгууллага	Төрийн банк	
9	Тавигдах шаардлагууд	Барилгын гадна хана дулаалгатай металл хавтан өнгөлгөөтэй байх бөгөөд хавтангийн өнгө, хуваалтыг захиалагчаас өгөгдсөн өнгөний код, хуваалтын дагуу гүйцэтгэх	
		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн налуу шат, шатны бариул зэрэг нь барилгын норм дүрмийн шаардлагыг хангасан байх бөгөөд гадна хаалганы онгойлтыг налуу шатны чиглэлд тохируулан суурилуулах	
		Барилгын оффисийн өрөөний ханыг “Extra color” брендийн В1661 кодтой угаадаг лактай эмульсээр, гүйлгээ заал, тамбур, зуух, щитний өрөөний ханыг эмульсны өнгөтэй ижил өнгийн тосон будгаар будах, теллерийн хэсгийн шалыг зурагт заасан хэмжээсийн дагуу хийхээс гадна паркетан шал, үйлчилгээний заалны плитан шал нь банкны стандарт өнгөний дагуу байх, гонхны дотор шал нь хальтардаггүй плита, гадна довжоо, налуу шат, шатны марш нь барзгар боржин чулуу байна.	
		Барилгын гадна хаалга даацын металл рамтай ганжуулсан шилэн хаалга, гонхны гадна дулаалгатай хамгаалалтын листэн хаалга, 3 давхар шилтэй вакуман цонх, цонхонд хамгаалалтын төмөр решёткатай байх бөгөөд цонхны хуваалт, онгойлтыг зургийн дагуу гүйцэтгэх;	
		Гадна дотор хяналтын камер, дохиолол хамгаалалтын тоног төхөөрөмжийн далд монтажийн ажлыг зургийн дагуу хийх бөгөөд камер, дохиоллын тоног төхөөрөмж нь захиалагчаас өгөгдсөн үзүүлэлтийг хангасан байна.	
		Гадна цахилгааны кабелийн ажлыг техникийн нөхцлийн дагуу хийгдсэн зургийн дагуу барилгын норм дуртийн дагуу хийж гүйцэтгэх	

		Барилгын цахилгааны нөөц тэжээлд цахилгаан моторыг /мотор нь банканд байгаа/ ашиглах тул ерөнхий шитэнд зургийн дагуу холбох;
		Барилгын ажлын төсөвт өртөгт барилга угсралтын ажил /дотор тоног төхөөрөмжийн ил далд монтажийн ажлууд орно/, гадна цахилгааны угсралтын ажил, гадна тохижилтын /гадна хашаа, авто болон явган зам талбай, ногоон байгууламж, гадна гэрэлтүүлэг, туслах байгууламжууд/ ажлууд, барилгыг байнгын ашиглалтанд оруулсанаар барилгын кадастрын гүйцэтгэлийн зургийг мэргэжлийн компаниар гүйцэтгүүлэх зардал, мөн орон нутгийн ГХХБГ-аас хийгдэх захиалагчийн хяналтын зардалуудыг оруулан тооцно.
10	Онцгой нөхцөл	Газар чичирхийлэлийн 9 балл -д хамрагдах, овойлтгүй, гэсгэлэн байдалтай Элсэнцэр чигжээстэй хайрган, дунд зэргийн төвөгтэй /цэвдэг/ хөрстэй тул геологийн судалгааны дүгнэлттэй сайтар танилцах шаардлагатай.
		Олон жилийн цэвдэг хөрсийг гэсгээхгүй барих 1-р зарчмыг баримтлан норм дүрэмд заасан хугацаанд гүйцэтгэх;
		Барилгын суурийг нээсний дараа зохиогчийн хяналт заавал хийлгэх;
		Цэвдэгтэй болон онцгой нөхцөлд барилга барьж байсан туршлагатай байх;

Тайлбар:

1. Барилга угсралтын ажлыг гүйцэтгэхдээ батлагдсан зургийн дагуу захиалагчийн болон авторын хяналтанд дор гүйцэтгэнэ.
2. Орон нутгийн ГХБХГазар, мэргэжлийн хяналтын байцаагч болон банкны салбар нэгжийн удирдлагуудтай тогтмол хамтран ажиллана.

Боловсруулсан: ЕҮХ-ийн инженер /гэрээт/  М.Өнөрцэцэг

Хянасан: ЕҮХ-ийн захирал  Н.Ганзориг